



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагыг
магадлан итгэмжлэх шалгуур
үзүүлэлт батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг нэгдүгээр, нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг хоёрдугаар, сум дундын эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг гуравдугаар, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг дөрөвдүгээр, өрхийн эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг тавдугаар, сувиллыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны "Шалгуур үзүүлэлт батлах тухай" 395 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



САЙД

Н.УДВАЛ

080012